



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/88

Улаанбаатар хот

“Ажлын байрны түрээс” нэртэй тендер
сонгон шалгаруулалт зохион байгуулах
үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.10, 8 дугаар 8.3.1, 8.4, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 заалт, 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх хэсэг, "Босго үнэ шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ажлын байрны түрээс” нэртэй сонгон шалгаруулалт зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төсвийн хүрээнд худалдан авах ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж ажиллахыг Үнэлгээний хороо (Д.Бямбадорж)-нд үүрэг болгосугай.

3. Үнэлгээний хороонд ажиллах ажилтнуудын "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх мэдэгдэл"-ийг гаргуулан байгууллагын ЭБАТ-д бүртгүүлж, худалдан авах ажиллагаатай холбогдох баримт бичгээр архивын нэгж үүсгэж, холбогдох албан тушаалтад хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Р.Энхсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/18 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай


ДАРГА



Д.НАРАНТУЯА

1432 010989

Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын
газрын даргын 2022 оны 04 дугаар сарын 26-ны
өдрийн 4 дугаар тушаалын хавсралт



**“АЖЛЫН БАЙРНЫ ТҮРЭЭС” НЭРТЭЙ ТЕНДЭР СОНГОН
ШАЛГАРУУЛАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ
ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Бямбадорж (ЭЭХХЗГ, ЭҮХ-ийн дарга)

Гишүүд:

Г.Цэцэнсанаа (ЭЭХХЗГ, ЭХГ-ын дарга)

Б.Батжаргал (Эрүүл мэндийн технологи
инновацийн хамтын ажиллагааны хүрээлэн
НҮТББ-ын Удирдах зөвлөлийн гишүүн)

Т.Отгонтөгс (Сэтгэлд мөнхөрсөн үйлс
ТББ-ын зохицуулагч)

Нарийн бичгийн дарга:

Р.Энхсүрэн (ЭЭХХЗГ, ЭТТГ-ын
мэргэжилтэн)

1432 010999